

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ БҮХИЙ ИРГЭД ХАРИЛЦАН
ВИЗГҮЙ ЗОРЧИХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ УНГАР УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хоёр улсын дипломат болон албан паспорт бүхий иргэд харилцан визгүй зорчиж байх талаар дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг талын хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорттай иргэд хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт түүний олон улсын нээлттэй хилийн боомтоор орж, мөн тусгай зөвшөөрөлгүйгээр гарч болно.

2. Дээр дурдсан паспорттай хэлэлцэн тохирогч нэг талын иргэд 30 хүртэл хоногоор Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байж болно. Хэлэлцэн тохирогч аль нэг талын Дипломат төлөөлөгчийн газраас бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллага байх хугацааг нь 30 хоногоор сунгаж болно.

Хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэр дэх хэлэлцэн тохирогч нэг талын дипломат, консулын буюу худалдааны төлөөлөгчийн газрын бие бүрэлдэхүүний дипломат буюу албан паспорттай гишүүн албан үүргээ гүйцэтгэж байгаа хугацаандаа нөгөө талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр орж, тусгай зөвшөөрөлгүйгээр оршин сууж, гарч болно.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрладаг олон улсын байгууллагад төлөөлөгчөөр суугаа хэлэлцэн тохирогч нэг талын дипломат буюу албан паспорттай иргэдэд нэгдүгээр заалтад олгосон эрх нэгэн адил хамаарна.

3. Энэхүү зүйлийн 1, 2 дугаар заалтад дурдсан хүмүүсийн томилолтын хугацаанд тэдгээрийн гэр бүл болон насанд хүрээгүй хүүхдүүд дипломат, албан паспорттай буюу эцэг, эхийн паспортад тэмдэглэгдсэн бол энэхүү нэгдүгээр заалтад тусгасан эрхийг нэгэн адил эдэлнэ.

Гуравдугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрээр тогтоогдсон визгүй зорчих дипломат, албан паспорт эзэмшиж буй иргэд хэлэлцэн тохирогч нөгөө талын хүчин төгөлдөр хууль дүрмийг биелүүлэх үүрэгтэй.

2. Хэлэлцэн тохирогч нэг тал нөгөө талынхаа иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах буюу байх хугацааг нь богиносгох эрхтэй.

3. Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь нийгмийн аюулгүй байдал болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү хэлэлцээрийн заалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоож болно. Ийм арга хэмжээ авсан буюу хэлэлцээрийг сэргээсэн тухайгаа хэлэлцэн тохирогч нөгөө талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэж байна.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр талын эрх бүхий байгууллагууд энэхүү хэлэлцээрт гарыг үсэг зурснаас хойш тус хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохоос 30 хоногийн өмнө дипломат шугамаар хүчин төгөлдөр паспортуудын загварыг харилцан солилцоно. Аль нэг тал нь паспортаа шинэчлэвэл түүнийг хэрэглэхээс 30 хоногийн өмнө нөгөө талдаа загварыг өгсөн байна.

Тавдугаар зүйл

Нэгдүгээр зүйлийн нэгдүгээрт заасан хэлэлцэн тохирогч нэг талын иргэд хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт зорчин явах баримт бичгээ үрэгдүүлбэл энэ тухайгаа тэр талын эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдээллийн дагуу магадлагааг олгоно.

Зургадугаар зүйл

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн визийн журмыг өөрчлөх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Ард Улсын Засгийн газар хоорондын 1967 оны нэгдүгээр сарын 23-ны өдөр Будапешт хотод байгуулсан хэлэлцээр, түүний хавсралт протокол хүчингүй болно.

Долдугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрийг хэлэлцэн тохирогч хоёр талын Засгийн газар батална. Хэлэлцэн тохирогч хоёр тал баталсан тухайгаа дипломат шугамаар бичгээр харилцан мэдэгдэнэ.

2. Хэлэлцээрийг баталсан тухай аль нэг талын сүүлийн мэдээлэл хүлээн авсан өдрөөс эхлэн 30 дахь хоногтоо хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээрийг тодорхой бус хугацаагаар байгуулсан бөгөөд хэлэлцэн тохирогч аль нэг тал дипломат шугамаар энэхүү хэлэлцээрийг цуцлах хүсэлтээ бичгээр мэдэгдэх хүртэл хүчин төгөлдөр байна. Цуцлах мэдүүлэг авсан өдрөөс хойш 60 хоногийн дараа энэхүү хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1992 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Будапешт хотноо монгол, унгар хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх хувь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Гарын үсэг

БҮГД НАЙРАМДАХ УНГАР УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Гарын үсэг